



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021-02-25 № 358

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙН ДЭМЖИХ ДЭД САНГИЙН  
ДАРГА, ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
С.НЯМДОРЖ ТАНАА

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих  
дэд сангийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн  
аудитын тайлан, гэрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 24 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002030503



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.02.25 № 359

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР  
ЭРХЛЭЛТИЙН ДЭМЖИХ ДЭД  
САНГИЙН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД  
ЗАХИРАГЧ С.НЯМДОРЖ ТАНАА

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1,8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### Аудитын гол асуудал

Худалдан авалт болон ажил үйлчилгээний 37,145.7 мянган төгрөгийн төлбөрийн и-баримтыг бүрдүүлээгүй, ажилд зуучлах үйлчилгээний 1 хүний

батлагдсан зардлыг 21,291.5 мянган төгрөгөөр, цагийн ажилд зуучлах үйлчилгээний 1 хүний батлагдсан жишиг нормыг 23,482.5 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлсэн, гэрээний заалтыг баримтлаагүй 4 байгууллагад 9,396.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлсэн, 9,759.0 төгрөгийн насжилт өндөртэй авлагын үлдэгдэлтэй гарсан, 9,611.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо хийлсэн актаар баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар”-ын 6.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох” тухай 2019 оны А/82 тоот тушаалын 3 дугаар хавсралтын 6 заалтууд болон УСНББОУС -1-ын 27 дугаар зүйлтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлэгээ батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  М.ЭРДЭНЭЖАРГАЛ





### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2021/58/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Улаанбаатар хот  
2021 он

“Их монгол хөлөг Аудит” ХХК

Захирал: С.Тунгалаг

утас: 70001778

Цахим хаяг: [info@imkaudit.mn](mailto:info@imkaudit.mn)

Аудитор: Г.Ариунбат

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

“Ихмонгол хөлөг Аудит” ХХК

Утас: 70001778

Цахим хаяг: [info@imkaudit.mn](mailto:info@imkaudit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХХҮЕГ	Хөдөлмөр Халамж Үйлчилгээний ерөнхий газар
НХЭГ	Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	10
3.Аудитын тайлан .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.9. Аудитын илрүүлэлт .....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	17
4. Менежментийн захидал.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

## 1. Төрийн аудитын санал дүгнэлт

НИЙСЛЭЛИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН  
ДЭМЖИХ ДЭД САНГИЙН ДАРГА,  
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
С.НЯМДОРЖ ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 100.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Аудитын гол асуудал

Худалдан авалт болон ажил үйлчилгээний 37,145.7 мянган төгрөгийн төлбөрийн и-баримтыг бүрдүүлээгүй, ажилд зуучлах үйлчилгээний 1 хүний батлагдсан зардлыг 21,291.5 мянган төгрөгөөр, цагийн ажилд зуучлах 1 хүний батлагдсан жишиг нормыг 23,482.5 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлсэн, гэрээний заалтыг баримтлахгүйгээр 4 байгууллагад 9,396.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлсэн, 9,759.0 төгрөгийн насжилт өндөртэй авлагын үлдэгдэлтэй гарсан, 9,611.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо хийлсэн актаар баталгаажуулаагүй, зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөн заавар”-ын 6.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох” тухай 2019 оны А/82 тоот тушаалын 3 дугаар хавсралтын 6 заалтууд болон УСНББОУС -1-ын 27 дугаар зүйлтэй нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

М.ЭРДЭНЭЖАРГАЛ



**2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**  
**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	45,501,800.00	39,784,000.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
321	Үнэт цаас	-	-
33	АВЛАГА	45,501,800.00	30,388,000.00
335	Бусад авлага	45,501,800.00	30,388,000.00
3351	Байгууллагаас авах авлага	5,545,300.00	3,345,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	39,956,500.00	27,043,000.00
336	Зээлийн авлага	-	-
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	-
34	УРЬДЧИЛГАА	-	9,396,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	9,396,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	-
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	45,501,800.00	39,784,000.00
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,108,500.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,108,500.00	-
413	Өглөг	13,108,500.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,499,500.00	-
4136	Бусад өглөг	10,609,000.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	49,000.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	10,560,000.00	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	32,393,300.00	39,784,000.00
51	Засгийн газрын хувь оролцоо	32,393,300.00	39,784,000.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	-
512	Хуримтлагдсан үр дүн	32,393,300.00	39,784,000.00
51210	Өмнөх үеийн үр дүн	207,172,843.61	45,501,800.00
51220	Тайлант үеийн үр дүн	(174,779,543.61)	(5,717,800.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	45,501,800.00	39,784,000.00

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,186,214,800.00	442,033,700.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,214,800.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	2,214,800.00	-
120003	Торгуулийн орлого	2,214,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,184,000,000.00	442,033,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,184,000,000.00	251,000,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,184,000,000.00	251,000,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	191,033,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	191,033,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,360,994,343.61	447,751,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,360,994,343.61	447,751,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,461,040.00	2,021,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,461,040.00	2,021,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,461,040.00	2,021,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,357,533,303.61	445,730,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,163,697,587.92	413,247,691.61
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,163,697,587.92	413,247,691.61
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,069,500.00	1,000,300.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,069,500.00	1,000,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	98,890,715.69	18,568,608.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,890,715.69	18,568,608.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,875,500.00	12,913,500.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,875,500.00	12,913,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(174,779,543.61)	(5,717,800.00)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(174,779,543.61)	(5,717,800.00)

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,362,194,343.61	455,947,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	94,945,000.00	13,913,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	94,945,000.00	13,913,800.00
120003	Торгуулийн орлого	2,214,800.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	92,730,200.00	13,913,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	89,875,500.00	12,913,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,854,700.00	1,000,300.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,267,249,343.61	442,033,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,267,249,343.61	251,000,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,184,000,000.00	251,000,000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	83,249,343.61	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	191,033,700.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	191,033,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,362,194,343.61	455,947,500.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,362,194,343.61	455,947,500.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,461,040.00	2,021,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,461,040.00	2,021,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,461,040.00	2,021,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,358,733,303.61	453,926,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,164,897,587.92	421,443,691.61
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,164,897,587.92	421,443,691.61
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,069,500.00	1,000,300.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,069,500.00	1,000,300.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	98,890,715.69	18,568,608.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	98,890,715.69	18,568,608.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	89,875,500.00	12,913,500.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	89,875,500.00	12,913,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	-
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/			
	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	32,393,300.00	32,393,300.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	32,393,300.00	32,393,300.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн				-
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	32,393,300.00	32,393,300.00
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	32,393,300.00	32,393,300.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	13,108,500.00	13,108,500.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	45,501,800.00	45,501,800.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(5,717,800.00)	(5,717,800.00)
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	39,784,000.00	39,784,000.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	455,951,820.00	250,983,890.61	204,967,929.39	55.05
21	УРСГАЛ ЗАРДАЛ	455,951,820.00	250,983,890.61	204,967,929.39	55.05
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,032,100.00	898,400.00	2,133,700.00	29.63
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,032,100.00	898,400.00	2,133,700.00	29.63
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,032,100.00	898,400.00	2,133,700.00	29.63
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	452,919,720.00	250,085,490.61	202,834,229.39	55.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	452,919,720.00	250,085,490.61	202,834,229.39	55.22
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	452,919,720.00	250,085,490.61	202,834,229.39	55.22
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
14	БУСАД ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1.00	1.00	-	100.00
620001	Удирдах ажилтан	-	-	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
620004	Гэрээт ажилтан	-	-	-	-

**2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэмэлт санхүүжилтийн тайлан**  
/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	172,481,201.00	172,481,201.00	-	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	172,481,201.00	172,481,201.00	-	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,123,000.00	1,123,000.00	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,123,000.00	1,123,000.00	-	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,123,000.00	1,123,000.00	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	171,358,201.00	171,358,201.00	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	171,358,201.00	171,358,201.00	-	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	171,358,201.00	171,358,201.00	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-	-	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл			-	-
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл			-	-
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл			-	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	189,000,000.00	189,000,000.00	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	189,000,000.00	189,000,000.00	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1.00	1.00	-	-
620001	Удирдах ажилтан	-	-	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	1.00	1.00	-	-
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	-
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСДИЙН ТОО	-	-	-	-

### 3. Аудитын тайлан

#### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга С.Нямдорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 06-наас 2021 оны 02 дугаар сарын 20-ны хооронд Ихмонгол хөлөг Аудит ХХК-ийн захирал С.Тунгалаг хянан удирдаж, ахлах аудитор Г.Ариунбат, аудитын менежер Б.Батцэцэг, аудиторын туслах Т.Оюун, Г.Ариунболд нар хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Ихмонгол хөлөг Аудит ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 24 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, сангийн үйл ажиллагааны тогтвортой бөгөөд шударга тогтолцоог бий болгож, хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг иргэдэд хүргэснээр нийслэлийн ажил олгогчид, ажиллах хүчнийг даяаршиж буй дэлхийн эдийн засагт хөл нийлүүлж амжилтад хүрэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино. Үүнд:

- Засгийн Газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд үйлчилгээний нэр төрөл, чанар, арга хэлбэрийг боловсронгуй болгох, арга зүйг сайжруулах үндсэн дээр, иргэн хуулийн этгээдэд үйлчилгээг шуурхай хүргэх;
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ нийт ажлын байр, шинээр бий болсон, өөрчлөлт орсон, сул чөлөөтэй ажлын байрны талаарх мэдээлэл цуглуулах, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх
- Ажил хайгчийг тохирох ажлын байранд зуучлах;  
Иргэнд үйлдвэрлэл дээрх сургалт, мэргэжлийн болон давтан сургалт, явуулын болон зайны сургалт, шавь сургалтын зэрэг хэлбэрээр богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх, хөгжүүлэх гэж тодорхойлсон.

Тайлант хугацаанд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2019-2020 оны хөтөлбөрүүдийг батлах тухай” Хөдөлмөр Эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн 01 дүгээр тогтоол;

- Нийгмийн даатгалын тухай хуулиар даатгуулагч болон ажил олгогчоос төлөх шимтгэлийн өөрчлөлт;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх өөрчлөлт;
- “Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2020 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай” ХХҮЕГ-ын даргын А/144 дүгээр тушаал
- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2020 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай” ХХҮЕГ-ын даргын 2020 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/144 дүгээр тушаал;
- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2020 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай” ХХҮЕГ-ын даргын 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/166 дугаар тушаал;
- Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн 2020 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай” ХХҮЕГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/186 дугаар тушаал;
- “ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээний үйл ажиллагааны төсвийг батлах тухай” Хөдөлмөр эрхлэлтийн нийслэлийн салбар зөвлөлийн 2020 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн 03 дугаар тогтоол;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д” Нягтлан бодогч нь мэргэжлийн үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомжийг мөрдөж ажиллана”;(2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн)
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д” Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол 10-аас доошгүй жил хадгална”; (2020 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.)
- Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ны 382 дугаар тогтоолын 5-д “ Төрийн захиргааны албан хаагчийн нэмэгдэл хөлс, төрийн үйлчилгээний албан хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тооцож олгосугай; өөрчлөлтүүд орсон байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Төсвийн шууд захирагч нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ХХҮЕГ-ын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/289 тоот тушаалаар шинэчлэн баталсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### **3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар буюу 13,609.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,021.3 мянган төгрөгөөр буюу 1.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	45,501.8	30,388.0	(14,113.8)
Урьдчилгаа	-	9,396.0	9,396.0
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	-	-	-
<b>Нийт хөрөнгө</b>	<b>45,501.8</b>	<b>39,784.0</b>	<b>(5,717.8)</b>
Өр төлбөр	13,108.5	-	(13,108.5)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	32,393.3	39,784.0	7,390.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>45,501.8</b>	<b>39,784.0</b>	<b>(5,717.8)</b>

Төсөвт байгууллага нь мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг оны эцэст төсөвт буцаан төвлөрүүлдэг учир мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй гарсан байна.

Авлага дансны эхний үлдэгдлийн 14,113.8 мянган төгрөгөөр бууруулж, 30,388.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Энэ нь өмнөх оны зээлийн үлдэгдлээс 14 иргэн, 2 байгууллагын 15,123.3 мянган төгрөгийн зээлийн өрийн үлдэгдлийг төлж барагдуулснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр үлдэгдэлгүй байгаа нь оны эхний 3 байгууллагад төлөх 13,108.5 мянган төгрөгийн үлдэгдлийг Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн газрын даргын А/43 тоот тушаалаар хааснаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 39,784.0 мянган төгрөг болж 7,390.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант алдагдал өмнөх оноос буурснаас шалтгаалжээ.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 741,966.3 мянган төгрөгөөр буюу 62.7 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс санхүүжилтийн орлогод материаллаг өөрчлөлт гарсан байна.

Энэ нь Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан зарим хөтөлбөрүүдийг Ковид-19 цар тахлын хөл хорионы улмаас бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсноос шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 913,242.8 мянган төгрөгөөр буюу 67.1 хувиар буурсан байна. Өмнөх онд хэрэгжсэн хөтөлбөрүүдээс тайлант онд дараах хөтөлбөрүүд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ;
- Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр;
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих;
- Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНХ-ийн 3 талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавх бэхжүүлэх сургалт;

Хэрэгжсэн хөтөлбөрүүдээс Ажилд зуучлах үйлчилгээ өмнөх оноос 109,291.2 мянган төгрөгөөр буюу 70.5 хувиар, ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн зардал 205,382.5 мянган төгрөгөөр буюу 37.9 хувиар тус тус буурсан байна. Энэ нь тайланд онд Ковид-19 цар тахлын улмаас төсөл хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байсантай холбоотой байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,185,542.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,185,542.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,185,542.1 мянган төгрөгөөр мянган төгрөгөөр баталсан ч дараах байдлаар төсөвт өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

- 2020 оны 6 сарын 12-ны өдрийн А/114 тушаалаар төсвийн орлого, зарлагыг 1,185,542.1 мянган төгрөгөөр;
- 2020 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн А/166 дугаар тушаалаар 505,676.8 мянган төгрөгөөр;
- 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/186 дугаар тушаалаар 455,951.2 мянган төгрөгөөр болгон бууруулсан.

Хөдөлмөр эрхлэлтийн нийслэлийн салбар зөвлөлийн 2020 оны 8 дугаар сарын 24-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хөтөлбөрийн төсвийг дараах байдлаар баталсан байна. Үүнд:

- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний зардлыг 202,000.0 мянган төгрөгөөр
- Ажилд зуучлах үйлчилгээний үйл ажиллагааны төсвийг 593,000.0 мянган төгрөгөөр;
- Мэргэжлийн болон давтан сургалт зохион байгуулах арга хэмжээний төсвийг 231,510.0 мянган төгрөгөөр;
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрийн гарааны бизнесийг хөгжүүлэх арга хэмжээний үйл ажиллагааны төсвийг 160,000.0 мянган төгрөгөөр буюу 1,186,510.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийн нийслэлийн салбар зөвлөлийн баталсан төсвийн төлөвлөлт нь ХХҮЕГ-ын даргын баталсан төсөвтэй нийцээгүй байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 455,951.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 452,919.7 мянган

төгрөгийг улсын төсвөөс 3,032.1 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 250,085.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 898.4 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын /орон нутгийн/ төсвөөс 250,085.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 237,172.0 мянган төгрөгийг зарцуулж 12,913.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 237,172.0 мянган төгрөг буюу 94.8 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 171,358.2 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,123.0 мянга, нийт 172,481.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс урсгал үйл ажиллагааны зардалд 189,000.0 мянга төгрөгийг зарцуулжээ.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны [shilendans.gov.mn](http://shilendans.gov.mn) цахим хуудсанд сангийн дарга, нягтлан бодогчийн мэдээллийг шинэчилж, өөрчлөөгүй, 12 удаагийн мэдээг хожимдуулж, 35 удаагийн мэдээ байршуулаагүй, 29 удаагийн орлого, зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 25,498.5 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгснөөс 13,108.5 сая төгрөгийн 1 зөвлөмжөөс бусад зөвлөмжийг хэрэгжүүлж, хэрэгжилт 80 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	25,498.5	4	12,390.0	1	13,108.5	80%
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>25,498.5</b>	<b>4</b>	<b>12,390.0</b>	-	-	<b>80%</b>

Хэрэгжүүлээгүй 13,108.5 мянган төгрөгийн 1 зөвлөмжид 1 албан шаардлага хүргүүлэв.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,265,317.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,141,523.0 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 9,396.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 64,144.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 50,254.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Байгууллагын харилцах дансаар нэр данс зөрүүтэй, данс андуурсан 1,057,634.0 мянган төгрөгийн гүйлгээг мөнгөн хөрөнгийн журналд бүртгээгүй байсныг залруулав.

2. Авлагын дэлгэрэнгүй бүртгэлд тусгасан 83,889.3 төгрөгийн авлагын үлдэгдлийг дансны бичилт хийхгүйгээр хасах утгатайгаар бүртгэж үлдэгдлийг хассаныг залруулав.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 73,540.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 9,396.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 64,144.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв. Үүнд:

- Гэрээний заалтыг баримтлахгүйгээр 4 байгууллагад нийт 9,396.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", УСНББОУС -1-ын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг" заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

- Нийт 2 иргэнтэй холбоотой 9,759.0 мянган төгрөгийн насжилт өндөртэй авлагын үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8. "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", УСНББОУС 1-ын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг" заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

- Санхүүгийн тайланд тусгасан 7 иргэнтэй холбоотой нийт 9,611.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг тооцоо хийлсэн актаар баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС 1-ын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын

санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг” заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

- Ажилд зуучлах үйлчилгээний 1 хүний батлагдсан зардлыг 6.1 мянган төгрөгөөр буюу 21,291.5 мянган төгрөгөөр, цагийн ажилд зуучлах 1 хүний батлагдсан жишиг нормыг 20.3 мянган төгрөгөөр буюу 23,482.5 мянган төгрөгөөр тус тус төсвийг хэтрүүлж зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээний нэгжид ногдох зардлын хэмжээг шинэчлэн тогтоох” тухай 2019 оны 3 дугаар сарын 05-ны өдрийн А/82 тоот тушаалын 3 дугаар хавсралтын 6, Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/186 тушаалын хавсралтаар баталсан зардлын төсөв болон УСНББОУС 1-ын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг” заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

#### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 50,254.1 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

#### **3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Дэлхий дахинд дэгдэж буй Ковид-19 халдварын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шалгагдагч байгууллагаас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн хөрөнгөөр бэлтгэсэн эргэлтийн хөрөнгөнд биет тооллого хийгээгүй, төсвийн төлөвлөлт, түүнтэй холбогдох заавар журмын хэрэгжилтийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

#### **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### **3.1 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал**

###### **3.1.1 Илрүүлэлт:**

Тайлант хугацаанд хийгдсэн зарим худалдан авалт болон ажил үйлчилгээний төлбөрийн 37,145.7 мянган төгрөгийг И баримтыг (бэлтгэн нийлүүлэгч байгууллага И баримтыг 24,552.0 мянган төгрөгөөр илүү, 12,593.7 мянган төгрөгөөр дутуу цахим системд бүртгүүлсэн) бүрдүүлээгүй.

###### **3.1.2 Эрсдэл:**

Хууль, тогтоомж хэрэгжихгүй байх, татварын хүү торгууль хүлээх, ашиглан шамшигдал үүсэх.

###### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6. "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөн заавар"-ын 6.5. Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж, худалдан авалт бүрийг e-barimt системийн төлбөрийн баримтаар баталгаажуулж байх.

###### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид анхаарч ажиллана.

##### **3.2 Удирдлагын дээд болон дотоод хяналттай холбоотой асуудал**

###### **3.2.1 Илрүүлэлт:**

Шилэн дансны [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд сангийн дарга, нягтлан бодогчийн мэдээллийг шинэчлээгүй, 12 удаагийн мэдээг хугацаа хоцроож, 35 удаагийн мэдээллийг байршуулаагүй, 29 удаагийн орлого, зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй байх

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.1.2. *"хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор"*; 6.4.5 *"цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"* заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв байршуулж байх;

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Цаашид анхааран ажиллана.

## **3.3 Балансын данстай холбоотой асуудал**

### **3.3.1 Илрүүлэлт:**

Нийт 3 байгууллагатай холбоотой 13,108.5 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулахгүйгээр Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн даргын 2020 оны А/43 тушаалаар хаасан байна.

### **3.3.2 Эрсдэл:**

Хөрөнгө завших, эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах.

### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, эрх бүхий дээд байгууллагын шийдвэрийг үндэслэн өр төлбөрийг хаах асуудлыг шийдвэрлэж байх.

### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Эрх бүхий дээд байгууллагад уламжлан шийдвэрлүүлж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллага болон "Ихмонгол хөлөг аудит" ХХК-д 2021 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### АУДИТЫН ТАЙЛАНГ

**Хянасан:**

Аудитын хоёрдугаар хэлтсийн дарга бөгөөд  
аудитын менежер

З.Мөнхбаяр

Аудитын менежер

А.Цогбаяр

**Бэлтгэсэн:**


Ихмонгол хөлөг Аудит” ХХК-ийн

Захирал

С.Тунгалаг

Ахлах аудитор

Г.Ариунбат





## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2021.02.20</b>	Аудитын нэр: <b>Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн дэд сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>НТАГ-2021/58/СТА-ТШЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн дэд сан</b>	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Шилэн дансны shilendans.gov.mn цахим хуудсанд сангийн дарга, нягтлан бодогчийн мэдээллийг шинэчилж, өөрчлөөгүй, 12 удаагийн мэдээ хожимдуулж, 35 удаагийн мэдээ байршуулаагүй, 29 удаагийн (2,879,981.0 мянган төгрөг) орлого, зарлагын гүйлгээг байршуулаагүй байна.	-	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	С.Нямдорж Т.Лхагва
2	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг холбогдох баримтуудтай тулган шалгахад 9,759.0 мянган төгрөгийн авлага үлдэгдэлтэй бөгөөд тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, он дамжсан авлага байна.	9,759.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Нямдорж Т.Лхагва
3	Байгууллагын харилцах дансаар нэр данс зөрүүтэй данс андуурсан гүйлгээг мөнгөн хөрөнгийн журналд бүртгээгүй байна.	1,057,634.0	Залруулах	Нягтлан бодогч	Т.Лхагва
4	Авлагын дэлгэрэнгүй бүртгэлд дансны бичилт хийхгүйгээр Нийс.Хөд.Эрх.Газар ХЭДСан /РД:5131448/83,249,343.61 төгрөг, Сангийн яамнаас авах авлага /640,000.00 төгрөг/ нийт 83,889.3 мянган төгрөгийг хасах утгатайгаар бууруулж бичилт хийсэн байна.	83,889.3	Залруулах	Нягтлан бодогч	Т.Лхагва
5	Авлагын үлдэгдлээс шүүхийн байгууллагад шилжүүлж, үлдэгдлийг тооцоо хийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	9,611.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Нямдорж Т.Лхагва

6	Нийт 3 байгуулахтай холбоотой өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүйгээр Газрын даргын 2020-12-30 А/43 тушаалаар хаасан байна.	13,108.5	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	С.Нямдорж Т.Лхагва
7	Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүнг нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнтэй тулгахад 42 байгууллагад 24,551.9 мянган төгрөгөөр илүү, худалдан авалтын дүн 7 байгууллагын дүн 12,593.9 мянган төгрөгөөр дутуу байна.	37,145.6	Зөвлөмж	Дарга Нягтлан бодогч	С.Нямдорж Т.Лхагва
8	Нийт 4 байгууллагад 9,396.0 мянган төгрөгийг гэрээний заалтыг баримтлахгүй урьдчилан шилжүүлсэн байна.	9,396.0	Төлбөрийн акт тогтоох	Дарга Нягтлан бодогч	С.Нямдорж Т.Лхагва
9	Ажилд зуучлах үйлчилгээний 1 хүний батлагдсан зардлыг 6.1 мянган төгрөгөөр буюу 21,291.5 мянган төгрөгөөр, цагийн ажилд зуучлах 1 хүний батлагдсан жишиг нормыг 20.3 мянган төгрөгөөр буюу 23,482.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	44,774.0	Албан шаардлага	Дарга Нягтлан бодогч	С.Нямдорж Т.Лхагва
<b>ДҮН</b>		<b>1,265,317.4</b>			